



**НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7,
1 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160 0035
Утас: (976-11) 32 71 99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2024.12.04 № 03/6925
танай _____-ны № _____-т

**НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ
БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗАРТ**

Нийслэлийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай” А/1412 дугаар захирамжийг хүргүүлэв.

Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

Хавсралт 1 хуудастай.

Хувийг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Нийслэлийн Өмчийн харилцааны газар, “Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар” ОНӨААТҮГ, “Тавантолгой түлш” ХХК-д.

ДАРГА



П.ХАДБААТАР

1110206383



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 03 өдөр

Дугаар А/7492

Улаанбаатар хот

Зохион байгуулалтын арга
хэмжээ авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1, 63.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн өмчит “Тавантолгой түлш” ХХК-ийн төрийн эзэмшлийн хувийг нийслэлийн өмчид шилжүүлсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг хууль тогтоомж, эрх үүргийн дагуу авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд үүрэг болгосугай.

1.1.Нийслэлийн гэр хорооллын бүсийн монгол гэрт амьдарч буй айл өрхүүдийг сайжруулсан зуухаар хангахад шаардлагатай төсвийн тооцоо судалгааг гаргаж, банк, санхүүгийн байгууллагаар дамжуулан зээлээр олгох асуудлыг судлахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Б.Энхжин)-т, сайжруулсан зуух үйлдвэрлэгч аж ахуйн нэгжтэй уулзалт зохион байгуулж, зуухны нөөцийн судалгаа гаргахыг Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар (Д.Мөнхбаатар)-т;

1.2.Сайжруулсан шахмал түлшийг хөдөө, орон нутаг руу тээвэрлэх, тусгай зөвшөөрөлтэйгөөс бусад түүхий нүүрсийг товчоодоор нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор Улаанбаатар хотын автотээврийн шалгах нэвтрүүлэх товчоодод 24 цагийн хяналт тавих үйл ажиллагааг зохион байгуулахыг Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар (Д.Мөнхбаатар), Нийслэлийн Цагдаагийн удирдах газар (О.Ганбат)-т, шаардлагатай төсвийг шийдвэрлэхийг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Б.Энхжин)-т;

1.3.“Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар” ОНӨААТҮГ-ын Сайжруулсан түлшний хяналтын хэлтсийн ажлын байрны асуудлыг судалж, шийдвэрлэхийг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (П.Хадбаатар)-т;

1.4.Сайжруулсан түлшний чанарыг шинэчлэн сайжруулах, үйлдвэрлэлийг алдагдалгүй, өртөг багатай ажиллах технологийг судлах, нэвтрүүлэх тооцоо, судалгаа гаргахыг “Тавантолгой түлш” ХХК (Ц.Лхагвасүрэн)-д, сайжруулсан түлшний борлуулалтыг “Юби карт” аппликэйшнээр борлуулах асуудлыг судлахыг

1110206590

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Мэдээллийн технологийн газар (Б.Даваанямд)-т, түлшний үйлдвэрлэл, нөөцлөлт, тээвэрлэлт, борлуулалтын үйл ажиллагааг шинэчлэх санал боловсруулахыг Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар (Д.Мөнхбаатар)-т,

1.5.Сайжруулсан шахмал түлш хэрэглэдэг айл өрхүүдийн яндан, зуухны бүрэн бүтэн байдал, угаарын хий мэдрэгчийн хэвийн ажиллагаанд хяналт тавьж, засвар үйлчилгээ үзүүлэхийг “Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар” ОНӨААТҮГ-т, иргэдийг угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах чиглэлээр холбогдох зөвлөмж, мэдээллийг бэлтгэн иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулахыг дүүргийн Засаг дарга, Нийслэлийн Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс (Г.Баярцэцэг), нутгийн захиргааны байгууллагын удирдлагуудад.

2.Дээр дурдсан асуудлуудын үр дүнг нэгтгэн Засаг даргын зөвлөлийн хуралдаанд 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган улирал бүр тайлан, мэдээг нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнд танилцуулж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч (А.Амартүвшин)-д даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР